

Христтэй адил багш болж сайжрах нь Хувийн үнэлгээ

Багшийн хувьд бид суралцагчдадаа Есүс Христэд итгэх итгэлээ хөгжүүлж, Түүнтэй илүү адил болоход нь туслахын тулд өөрсдийн хүчтэй болон сул талуудаа олж тодорхойлох хэрэгтэй. Дараах үйл ажиллагаа нь Христтэй адил заах зарчмыг амьдралдаа хэрэгжүүлэхэд тань туслах болно. Дараах мэдэгдэл тус бүр таныг багшийн хувьд хэр сайн тодорхойлж байгааг анхаарна уу. Мэдэгдэл бүрээс хамгийн тохиромжтой хариултыг сонгоно уу. 1. Ховор 2. Заримдаа 3. Тогтмол 4. Бараг үргэлж

Дараа нь Сүнсний чиглүүлгээр сайжруулахыг хүсэж байгаа зүйлсээ залбирч сонго. Хэд хэдэн зорилго тавьж, өөрийгөө сайжруулахад ашигла.

Есүс Христэд төвлөрөх

- ___ Би ямар ч зүйл зааж байсан Есүс Христийн талаар заадаг.
- ___ Би Есүс Христийн жишээг онцолдог.
- ___ Би суралцагчдад Их Эзэний хайр, хүч чадал, нинжин сэтгэлийг амьдралдаа олж харахад нь тусалдаг.
- ___ Би суралцагчдад Тэнгэрлэг Эцэг болон Есүс Христтэй харилцах харилцаагаа хүчирхэгжүүлэхэд нь тусалдаг.
- ___ Би суралцагчдад Есүс Христтэй илүү адил болохоор хичээл зүтгэл гаргахад нь тусалдаг.

Зааж байгаа хүмүүсээ хайрлах

- ___ Би суралцагчдыг Бурхан тэднийг хардаг шиг харыхыг эрмэлздэг.
- ___ Би заадаг хүмүүсийнхээ хэрэгцээ, давуу тал мөн нөхцөл байдлыг нь мэдэхээр хичээдэг.
- ___ Би суралцагч бүрийнхээ нэрийг залбиралдаа багтаадаг.
- ___ Би бүх хүнийг хүн хүндлэгдэж болон өөрсдийнх нь оролцоо үнэ цэнтэй болохыг мэдрэх аюулгүй орчинг бүрдүүлдэг.
- ___ Би тохиромжтой аргаар хайраа илэрхийлдэг.

Сүнсээр заах

- ___ Би заахын тулд сүнслэгээр бэлтгэдэг.
- ___ Би суралцагчдынхаа хэрэгцээний талаар хүлээн авсан сүнслэг өдөөлтөд хариу үйлдэл үзүүлдэг.
- ___ Би суралцагчдад Ариун Сүнсний хүчээр заахын тулд таатай орчинг бүрдүүлдэг.
- ___ Би суралцагчдадаа хувийн илчлэлт эрж хайн, танин мэдэж, түүнийхээ дагуу үйлдэхэд нь тусалдаг.
- ___ Би тогтмол гэрчлэлээ хуваалцаж, суралцагчдыг мэдрэмж, туршлага, гэрчлэлээ хуваалцахад урамшуулдаг.

Сургаалыг заах

- ___ Би өөрөө Есүс Христийн сургаалаас суралцдаг.
- ___ Би судруудаас болон хожмын үеийн бошиглогчдын үгээс заадаг.
- ___ Би суралцагчдад судрын үнэнийг эрж хайн, танин мэдэж, ойлгоход нь тусалдаг.
- ___ Би Есүс Христэд хөрвөгдөж, Түүнд итгэх итгэлийг нэмэгдүүлэхэд хөтлөх үнэнүүд дээр төвлөрдөг.
- ___ Би суралцагчдадаа Есүс Христийн сургаалаас өөрсдөдөө хамааралтай зүйлсийг олж мэдэхэд нь тусалдаг.

Хичээнгүйлэн суралцахад урих

- ___ Би суралцагчдад суралцаж байгаа зүйлдээ хариуцлагатай хандахад тусалдаг.
- ___ Би суралцагчдад Аврагчаа таньж мэдэхийн тулд сайн мэдээнээс өдөр бүр суралцдаг байхад урамшуулдаг.
- ___ Би суралцагчдыг сурахад бэлэн байхад урьдаг.
- ___ Би суралцагчдыг суралцаж байгаа үнэнийхээ талаар хуваалцахад урамшуулдаг.
- ___ Би суралцагчдыг сурч мэдсэн зүйлийнхээ дагуу амьдрахад урьдаг.